



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/349


Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед шаардлагатай вирусийн эсрэг эм болон хавдрын тусламж, үйлчилгээнд шаардлагатай зарим нэрийн эмэнд импортын лиценз олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2020 оны 188 дугаар тогтоолын 1 дүгээр заалт, Хүний эмийн зөвлөлийн 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монос Трейд ХХК-ны нийлүүлэх эмэнд импортын лиценз олгох жагсаалтыг нэгдүгээр, Цомбо ХХК-ны нийлүүлэх эмэнд импортын лиценз олгох жагсаалтыг хоёрдугаар, ЦарамТэнгэр ХХК-ны нийлүүлэх эмэнд импортын лиценз олгох жагсаалтыг гуравдугаар, Террамед ХХК-ны нийлүүлэх эмэнд импортын лиценз олгох жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай, Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, бодлогоор бүртгэх эмийн бүртгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
3. Импортолсон эмийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, импортлох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллах, эмийн сан, эрүүл мэндийн байгууллагыг эмээр тасралтгүй, жигд хангаж, зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхыг эм ханган нийлүүлэх байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 06...  
дугаар сарын 05-ны өдрийн А/349  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



МОНОС ТРЕЙД ХХК-ИЙ НИЙЛҮҮЛЭХ  
ЭМЭНД ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЖАГСААЛТ

№	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Импортох тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр, улс
1.	Фавипиравир	200мг №100	шахмал	33,6 хайрцаг	"Strides Pharma Science Limited , БНЭУ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны ...<sup>06</sup>  
дугаар сарын ...<sup>25</sup>-ны өдрийн ...<sup>01319</sup>  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЦОМБО ХХК-ИЙ НИЙЛҮҮЛЭХ  
ЭМЭНД ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЖАГСААЛТ

№	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Импортолох тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр, улс
1.	Кармустин /Нитсум/	100мг	тарилгын лиофилжуулсан нунтаг, уусгагч уусмалтай	40 фл	Celon Pharma, БНЭУ
2.	Мелфалан /Алкасел/	50мг	тарилгын лиофилжуулсан нунтаг, уусгагч уусмалтай	40 фл	Celon Pharma, БНЭУ
3.	Бусульфан /Буселон/	60мг/10 мл	тарилгын уусмал	20 фл	Celon Pharma, БНЭУ
4.	Бинорелвин /Бинелвин /	50мг/5мл	тарилгын уусмал	6 фл	Fresenius Kabi, БНЭУ
5.	Блеомицин /Блеоцел/	15ОУН /	тарилгын лиофилжуулсан нунтаг, уусгагч уусмалтай	50 фл	Celon Pharma, БНЭУ
6.	Карбоплатин /Кемокарб/	450мг/45мл	тарилгын уусмал	100 фл	Fresenius Kabi, БНЭУ
7.	Иринотекан /Иринотел/	100мг/5мл	тарилгын уусмал	450 фл	Fresenius Kabi, БНЭУ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны ...06  
дугаар сарын 25-ны өдрийн ...А/849  
дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ЦАРАМТЭНГЭР ХХК-НЫ НИЙЛҮҮЛЭХ  
ЭМЭНД ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЖАГСААЛТ

№	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Импортолох тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр, улс
1.	Паракайн (Пропаракайн гидрохлорид)	0.5%-5мл	нүдний дусал	500 ширхэг	"Sunway", БНЭУ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 06...  
дугаар сарын 05-ны өдрийн А/349  
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ТЕРРАМЕД ХХК-НЫ НИЙЛҮҮЛЭХ  
ЭМЭНД ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЖАГСААЛТ

№	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Импортолох тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр, улс
1.	Гропивирин /Инозин пранобекс/	500мг №50	шахмал	6500 хайрцаг	"Farmak" Украин
2.	Вестинорм /Бетагистин/	16мг №30	шахмал	6000 хайрцаг	"Farmak" Украин